



Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудас АТГ.мон хаягтай боллоо

Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудасны АТГ.мон гэсэн монгол домэйн нэр ашиглалтад орлоо. Ингэснээр иргэд дээрх кирилл монгол үсгийн хаягаар Авлигатай тэмцэх газрын www.iaac.mn цахим хуудсанд хандах боломжтой болов.

Түүнчлэн албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлдэг цахим хуудас www.meduuleg.iaac.mn нь МЭДҮҮЛЭГ.мон, төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлдэг цахим хуудас www.xasxom.iaac.mn нь ХАСХОМ.мон болж тус тус өөрчлөгдлөө.

Авлигатай тэмцэх газрын цахим хаяг руу эх хэлээрээ, монгол кирилл үсгээр бичиж хандсанаар иргэд тус байгууллагын бодлого, үйл ажиллагаатай танилцах, санал бодлоо илэрхийлэхэд илүү дөхөм болж байна. Тус байгууллагын кирилл үсгээр бичигдэх, шинэ домэйн нэр бүхий АТГ.мон нь www.iaac.mn хаягтай хамт ашиглагдах ажээ.

СУРВАЛЖЛАГА

Авлигатай тэмцэх газар бол айсан хүнд хөдөлдөг аргал юм



Т.МӨНХТУНГАЛАГ

Саяхны нэгэн өдөр УИХ-ын дэргэдэх байгууллагуудын дарга нар Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцлаа. Авлигатай тэмцэх газар нь УИХ-ын дэргэдэх байгууллагын нэг юм. Тус газрын дарга, тэргүүн комиссар Н.Ганболдын хэлснээр энэ уулзалт “үйлдвэрлэл дээр нь үзэж харах” зорилготой байв. Тэрээр хэлэхдээ “Монгол Улсад харьцангуй шинэ тулгар байгуулагдсан Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай газар дээр нь үзэж танилцах боломжийг та бүхэнд олгож байна. Ингэснээр УИХ-ын дэргэдэх төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо илүү нягтарч, бидний харилцаа, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол улам бэхжинэ гэдэгт итгэлтэй байна” гэлээ.

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцах уулзалтад УИХ-ын даргын ахлах зөвлөх С.Ламбаа, УИХ-ын даргын Эдийн засгийн бодлогын зөвлөх Д.Лхагвасүрэн, УИХ-ын даргын Нийгмийн бодлогын зөвлөх Ц.Буянцогтоо, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, Үндэсний Статистикийн хорооны дарга С.Мэндсайхан, дэд дарга Р.Содхүү, Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж, тус комиссын гишүүн П.Оюунчимэг, Н.Ганбаяр, Монголбанкны Тамгын газрын захирал Д.Чимэд-Юндэн,

Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн хэлтсийн ахлах хянан шалгагч Д.Гэрэлчулуун нар оролцов.

Танилцах уулзалт Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс эхэллээ. Энэ хэлтэс авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэднийг авлигатай тэмцэх арга барилд сургахаар ажилладаг юм. Улсын хэмжээнд төрийн гэх данстай бүх байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх ажлыг АТГ анх байгуулагдсан цагаасаа хийж ирсэн. Төлөвлөгөөг яаж хэрэгжүүлснээ төрийн байгууллагууд оны төгсгөлд тусгай шин жээчдээр үнэлүүлдэг байна. Уулзалтад оролцогчид энэ үнэлгээний талаар ихэд сонирхож байв. Үндэсний Статистикийн хорооны дарга С.Мэндсайхан “Манай байгууллага өнгөрсөн жил хангалтгүй үнэлгээ авсан. Энэ жил авлигаас урьдчилан сэргийлэх ажлаа сайжруулахын төлөө анхаарч ажиллана” гэв.

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах чиглэлээр тус хэлтсээс олон төрлийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулдаг байна.

СУРВАЛЖЛАГА

Авлигатай тэмцэх газар бол айсан хүнд хөдөлдөг аргал юм

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Тэр дундаа шүүхээр шийдвэрлэсэн албан тушаалын гэмт хэргийг кейсийн хэлбэрээр телевизийн нэвтрүүлэг болгох, нийгмийн зорилготой бүлгүүдэд ном, гарын авлага бэлтгэн түгээх зэрэгт түлхүү анхаардаг гэж Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Б.Бат-Отгон танилцуулав. Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж “Кейс жишээгээ бэлтгэхдээ хүний эрхийн талаар гойд анхаарах хэрэгтэй. Хэдийгээр гэмт хэрэг хийсэн ч тэр хүний эрхийн асуудал бас байгааг бодолцоорой” гэж хэллээ.

УИХ-ын дэргэдэх байгууллагуудын удирдлагад Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Ө.Энхтөр байцаалтын болон серверийн өрөөг үзүүлж, ажил байдлаа танилцуулав. Мөрдөн шалгах хэлтэс өнөөдрийн байдлаар 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, түүнд холбогдогч нь өндөр боловсрол мэдлэгтэй, тодорхой албан тушаал хашдаг, улс төр, эдийн засгийн нөлөөлөл ихтэй, эрсдлээ урьдчилан тооцож хууль бус үйлдлээ хууль ёсны мэт халхавчилсан байдаг зэрэг нь хэргийг ихээхэн ээдрээ, төвөгтэй болгож байдаг тул мөрдөн байцаалтын ажилд боломжит бүхий л арга хэрэгсэл, техник технологийг ашиглах нь энэ хэлтсийн ажлын хэрэгцээ шаардлага юм. Байцаалтын өрөө орчин үеийн техник төхөөрөмжөөр тоноглогдсоныг уулзалтад оролцогчид хараад ихэд олзуурхаж байлаа. Ялангуяа Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж “Ийм л өрөөтэй байвал хүний эрхийг зөрчихгүй байх боломжтой” гэж хэлэв. Тэрээр “Авлигатай тэмцэх газартай холбоотой гэрчийг дарамталсан гомдол гараагүй” гэж мөн онцоллоо. Мөрдөн шалгах хэлтсийн дарга Ө.Энхтөр “Албан тушаалын гэмт хэрэгт олон өмгөөлөгч оролцдог, ажилладаг. Тэр хэрээр мөрдөн байцаах ажиллагаанд хяналт өндөр байдаг юм” гэв. Хоригдож байгаа хүний эрх зөрчигдөж байгаа асуудлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага руу хандсан ажил зохион байгуулах хэрэгтэй юм байна. Гарсан алдаа зөрчил бүхнийг АТГ руу чихээд, тохоод байх нь зохисгүй юм гэдгийг УИХ-ын дэргэдэх байгууллагуудын дарга нар санал нэгтэй тэмдэглэн хэлж байлаа.

Дараа нь уулзалтад оролцогчдыг Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Ж.Батсайхан хүлээн авч, ажлаа танилцуулав. Улсын хэмжээнд 33 гаруй мянган төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, мэдээлж, хянаж, дүн шинжилгээ хийдэг энэ хэлтсийн ажлын ачаалал их байдаг юм байна гэж УИХ-ын даргын ахлах зөвлөх С.Ламбаа онцлон хэлэв. Харьцангуй шинээр батлагдсан хуулийн дагуу төрийн албан хаагчдын хөрөнгө, орлого дээр нэмээд

хувийн ашиг сонирхлын нь мэдүүлгийг бүртгэж авдаг болсон юм. Ингэснээр энэ ажил улсын хэмжээнд тогтолцооны шинжтэй болж нэгэнт төлөвшөөд байгаа ажээ. Тус хэлтсээс хэрэгжүүлдэг бас нэгэн чиг үүрэг нь нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах ажил билээ. “Энэ бичиг тун хэрэгтэй байдаг юм. Хэн нэгэн хүн тухайн албан тушаалд томилогдохоос өмнө тэр ажилтай харшилдах сонирхлын зөрчил байна уу үгүй юу гэдгийг мэдэх, энэ эрсдэлээс сэргийлэх бололцоо олгодоггоороо ихээхэн ач холбогдолтой” хэмээн Монголбанкны Тамгын газрын захирал Д.Чимэд-Юндэн хэлэв. УИХ-ын дэргэдэх байгууллагуудын удирдлага танилцах уулзалтыг дүгнэж үг хэллээ.

Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж: -Нүдээр үзсэн бүхэн үнэн гэж манай монголчууд ярьдаг. Юу гэж хэлүүлэх нь чухал биш. Өнөөдөр хүнд хэцүү байж мэднэ. Та нар төрийн хамгийн хүнд хэцүү албыг гүйцэтгэж байгаа шүү. Айсан хүнд аргал хөдөлнө гэдэг үг бий. АТГ бол чухам тэр аргал юм л даа. АТГ-аас айх учир хэнд байна вэ? Тэр хүнд асуудал байна гэсэн үг. Танай газрыг Үндсэн хуулийн бус байгууллага гэх мэтээр элдэв нэр хоч их өгдөг. Хийж байгаа ажил үйлс, үйл ажиллагаагаа ингэж нүдээр үзүүлж, харуулж байгаа нь тун зөв юм.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн: -Би өнөөдөр танайхаас туршлага судаллаа. Танай, манай ажлын ерөнхий онцлог адилхан. Ялагдсан, яллагдсан нь гомдол гаргагдаараа ижил. Авлигатай тэмцэх газарт итгэж болох юм байна гэдгийг би нүдээрээ үзлээ. Та нарын ажлын зовлон жаргалыг аавынхаа туршлагаар мэднэ. Та нар сайн хэлэгддэггүй. Гэвч бид төрдөө тангараг өргөсөн учир няцахгүй, зүтгэнэ.

Үндэсний Статистикийн хорооны дарга С.Мэндсайхан: -Энэ удаагийн уулзалтыг Авлигатай тэмцэх газар шинэлэг арга хэлбэрээр зохион байгууллаа. УИХ-ын дэргэдэх байгууллагууд нэг нэгийнхээ ажил байдалтай газар дээр нь үзэж харж танилцах нь зөв юм байна. Хувь хүнийхээ хувьд танай байгууллага надад айдастай санагддаг байсан. Гэтэл тийм биш юм байна. Миний зайнаас төсөөлж явсан тэр төсөөлөл өөр байна. Авлигатай тэмцэнэ гэдэг хэцүү бэрх ажил. Шинэ байгууллага, шинэ тогтолцоог бий болгосон. Одоо энэ ажлаа олон нийтэд бодитоор ойлгуулах шаардлагатай. Та бүхний ажилд улам их амжилт хүсье. УИХ-ын дэргэдэх байгууллагууд бие биеийнхээ ажилд дэм тус болж, цаашид ч хамтран ажиллаа.

Авлигатай тэмцэх газрын нэгэн өдрийн ажилтай танилцсан УИХ-ын дэргэдэх байгууллагуудын удирдлагууд дараагийн уулзалтыг Сонгуулийн ерөнхий хороонд зохион байгуулахаар тогтлоо.

Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл хамтран ажиллах Санамж бичиг байгуулав

Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөлийн хооронд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах Санамж бичиг байгууллаа. Санамж бичигт Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Н.Ганболд, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо нар гарын үсэг зурав.

Санамж бичгийг байгуулснаар нийтийн албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлыг урьдчилан судлах, төрийн албаны сонгон шалгаруулалт, ажлын байрны шаардлагад нийцүүлж нэр дэвшүүлэх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж хэвшүүлэх; нийтийн албан тушаалд томилогдохоор Төрийн албаны зөвлөл, түүний Салбар зөвлөл, аймаг, нийслэлийн Боловсролын газрын шийдвэрээр нэр дэвшсэн этгээдийн бүрдүүлэх бичиг баримтын төрөлд “нэр дэвшүүлсэн тухай” тогтоол, тушаал, албан бичгийг хавсаргасан байдал болон хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулсан асуудлыг нягтлан үзэх, хамтарсан шалгалтыг зохион байгуулах; улс төрийн нам, эвсэл бүлэг, тодорхой бүлэглэлийн ашиг сонирхлоор нийтийн болон төрийн албанд томилогдох, томилох явдал түүний үр дагавар, шалтгаан, нөхцөлийг тогтоож Улсын Их Хурал, түүний Байнгын хороонд танилцуулах; “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг эрх зүйн орчинд нийцүүлэх саналыг боловсруулахад санал дэмжлэг үзүүлж хамтран ажиллах; төрийн байгууллагууд авлигад өртөх эрсдэлтэй ажлын байрны жагсаалтыг батлан, тэрхүү албан тушаалд хувь хүнийг сонгон шалгаруулж авах тусгайлсан журам батлах талаар зөвлөмж боловсруулах зэрэг хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харилцан тохиролцов.

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Н.Ганболд төрийн албан хаагчдыг хувийн ашиг сонирхол, авлига, хээл хахуулиас ангид, шударга ажиллуулах, мөн төрийн захиргааны төв байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр Санамж бичгийн хүрээнд цаашид улам нягтарч хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийллээ. Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо Төрийн албаны тухай хуулийг боловсронгуй болгох шаардлага буйг дурдаад уг хуулийг шинэчилсэн найруулснаар бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орох бөгөөд Санамж бичиг байгуулсан нь энэ ажлын эхлэл болж байгааг тэмдэглэв.

БАРИМТ, МЭДЭЭЛЭЛ

Авлигатай тэмцэх газар 2015 оны нэгдүгээр улиралд юу хийв?

Авлигатай тэмцэх газар нь хуулиар хуульчлал чиг үүрэг, 2015 онд дэвшүүлсэн зорилт, жил, улирлын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан бөгөөд эхний улиралд хийсэн ажил, хүрсэн үр дүнг тайлагнаж байна.

Төрийн 121 байгууллага авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна

Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилго бүхий "Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал"-ын дагуу төрийн 81 байгууллагаас 74 нь, төрийн болон төрийн өмчийн оролцоотой 47, нийт 121 байгууллага 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээгээр хангалтгүй үнэлгээ авсан Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Гадаад хэргийн яам, Эрүүл мэнд, спортын яам, Мал эмнэлэг үржлийн газар зэрэг байгууллагын удирдлагуудад цаашид үнэлгээг ахиулах, санаачилгатай ажиллах талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан бөгөөд хангалтгүй үнэлгээ авсан Мал эмнэлэг, үржлийн газар, Налайх дүүрэг, Сангийн яам, Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газар, Барилгын хөгжлийн төв, Ховд, Говь-Алтай, Увс аймгийн 27 сум, 1 тосгонд тус тус ажлын хэсэг гарган ажиллалаа.

Мөрдөн байцаагчаас гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн 8 мэдэгдлийн мөрөөр хэрэгжилтийн байдлыг нь судлан үзлээ. Мэдэгдэл хүргүүлсэн 8 байгууллагын 4 нь Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн, 4 нь орон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтнууд байх бөгөөд гэмт хэрэгт холбогдсон нийт 19 албан тушаалтны дийлэнхи нь цагдаа, гааль, иргэний харьяал, шилжилт хөдөлгөөний газрын байцаагчид байна. Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Төрийн өмчийн хорооноос гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлүүдийг арилгуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдалтай биечлэн танилцав.

Хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцуулах ажлын хүрээнд өөртөө удаа дараа урамшуулал олгож, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга Ш.Хажидмаад сануулах, Налайх дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга П.Чинбатад сахилгын шийтгэлийг тус тус авахуулжээ. Мөн

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Баянгол дүүрэг байгуулагдсаны 50 жилийн ойд зориулж иргэд байгууллагын өгсөн хандивын орлогыг хүлээн авах, зарцуулах, тайлагнах журам"-ыг хянаж Баянгол дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар тогтоолоор хүчингүй болгуулсан байна.

Соён гэгээрүүлэх чиглэлээр бага насны хүүхдэд тохирсон асуулт зохиож хариултаар нь эвлүүлдэг дүрс хийх замаар puzzle тоглоом хийх, авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалтын слайд, асуулгыг сургалтад хамрагдаж байгаа бүлэгт тохируулан төрийн албан хаагч, төрийн удирдах албан тушаалтан, төрийн үйлчилгээний албан тушаалтан, эрх бүхий албан тушаалтан, эмч, багш зэргээр тусгайлан бэлтгэж, боловсруулаад байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 3.58 гарсныг танилцуулав

2014 оны судалгааны үр дүнгийн тооцооллыг гаргаж тайланг боловсрууллаа. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи төсөөллийн үнэлгээ 3.58 гарсныг парламентад суудалтай намууд болон төрийн захиргааны төв, хууль сахиулах байгууллагууд, шүүхийн төлөөлөлд танилцуулж, хэлэлцүүлэх уулзалт болон төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2014 оны судалгааны үр дүнг судалгаанд хамрагдсан байгууллагуудын төлөөлөлд танилцуулах ажлыг тус тус зохион байгуулав.

"Монгол Улсын Авлигын индекс тооцох аргачлал"-ыг боловсронгуй болгох зорилгоор яам, агентлаг болон судалгааны байгууллагын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгийн мөрөөр холбогдох засвар өөрчлөлтийг аргачлалын төсөлд тусгахаар ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулан явуулдаг судалгаануудыг холбогдох байгууллагуудад танилцууллаа.

Улсын хэмжээнд 38411 албан тушаалтан мэдүүлгээ бүртгүүлжээ

2014 оны ХАСХОМ мэдүүлбэл зохих 270 мэдүүлэг гаргагчийн 268 нь хуульд заасан хугацаандаа мэдүүлсэн байна. Улсын хэмжээнд 38423 хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 38422 мэдүүлэг гаргагч буюу 99,99 хувь нь бүртгүүлсэн. Үүнээс хуульд заасан хугацаандаа 38421 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн бол 1 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулж, 1 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж өгөхөөс татгалзсан байна.

Түүнчлэн нийт 175 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгаж дууссан

нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 125,8 хувиар илүү байгаа ажээ. Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой нийт хүлээн авсан өргөдөл, гомдлыг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 21,3 хувиар, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол нь 20,2 хувиар тус тус нэмэгдсэн байна. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 2831 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлжээ.

125 холбогдогчтой 101 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явууллаа

Авлигатай тэмцэх газрын 1800-1969 дугаарын утсаар болон бичгээр, мөн биечлэн ирүүлсэн нийт 286 гомдол, мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хүлээн авчээ. Эндээс гэмт хэргийн шинжтэй 108 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.1 хувиар өссөн байна. Гэмт хэргийн шинжтэй нийт 120 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 24-т нь эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсчээ.

Энэ оны 1 дүгээр улиралд Авлигатай тэмцэх газар хуульд заасан харьяаллын 146 үйлдэлтэй, 125 холбогдогчтой 101 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. Эдгээрээс төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулах зүйл ангид хамаарах хэрэг дийлэнх хувийг эзэлж байна.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл 17 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 18 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 8 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх, 10 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж, 6 хэргийг эрүүгийн хэрэгт нэгтгэж, одоогоор 42 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байна. Мөрдөн шалгасан хэргийн 48.5 хувийг шийдвэрлэсэн, хуулийн анхны хугацаанд хэрэг шийдвэрлэлт 30.6 хувьтай байв.

Гэмт хэргийн улмаас 26 тэрбум 176.4 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 393.8 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 3 тэрбум 950 сая төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалж, 240.5 сая төгрөгийн нуугдмал мөнгө, эд хөрөнгө илрүүлжээ.

Авлигатай тэмцэх газар нь салбар, бүтцийн нэгжгүй бөгөөд 2015 оны 1 дүгээр улиралд тус газрын 50 албан хаагч 187 хоног хөдөө орон нутагт томилолтоор ажиллажээ.

Авлигатай тэмцэх газрын 2015 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг дэлгэрэнгүйгээр доорх холбоосоор орж үзнэ үү.

<http://www.iaac.mn/content/553#.RV5U7cp8M68>

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ өмнөхөөс 0.05 пунктээр

НЭМЭГДЭВ

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” нь Авлигатай тэмцэх газрын үндсэн чиг үүргийн нэг юм. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааг Авлигатай тэмцэх газар 2010 оноос явуулж эхэлсэн бөгөөд энэ нь гурав дахь удаагийн судалгаа юм.

Төрийн нийтлэг үйлчилгээ буюу эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, халамж үйлчилгээ, нийгмийн даатгал, газрын алба, татвар, улсын бүртгэл, гааль, мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллага зэргээр үйлчлүүлсэн 3765 иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан 13 үзүүлэлтээр үнэлгээг гаргалаа.

2012 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал улсын бүртгэлийн байгууллага (0.31), газрын алба (0.24), эрүүл мэндийн байгууллага (0.16)-ын шударга байдлын түвшний үнэлгээ нэмэгдсэн бол гаалийн байгууллага (-0.40), татварын байгууллага (-0.16), нийгмийн даатгалын байгууллага (-0.10), боловсролын байгууллага (-0.04) пунктээр буурсан байна.

Сүхбаатар, Хөвсгөл, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаараа тэргүүлээ

Авлигатай тэмцэх газар олон нийтийн оролцоонд тулгуурласан, хөндлөнгийн хараат бус шинжээчдийн баг ажиллуулж, төрийн байгууллагын авлигын эсрэг 2014 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэсэн билээ. Хөндлөнгийн шинжээчдийн үнэлгээгээр Сүхбаатар, Хөвсгөл, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан авлигын эсрэг үйл ажиллагаа тэргүүлээ.

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2013 оны үнэлгээгээр Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар хамгийн муу буюу 2, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар 24 оноо авсан юм. Авлигатай тэмцэх газраас ажлын хэсэг томилж дээрх 2 аймгийн бүх суманд ажилласны үр дүнд энэ жил шинжээчдийн үнэлгээгээр Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар 75.7, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар 79 оноо авсан байна.

Хөндлөнгийн шинжээчдийн үнэлгээгээр энэ жил Орхон аймаг 82.3 оноо авчээ. Тус аймгийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд иргэдийн өргөдөл, гомдлыг олон талт хэлбэрээр хүлээж авах нөхцөлийг бүрдүүлсний зэрэгцээ төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, шат дамжлагыг цөөрүүлэх, шуурхай үйлчлэх зорилгоор “Иргэн төвтэй

төрийн үйлчилгээ” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 70353511” төвийг ажиллуулснаар иргэд төрийн үйлчилгээний талаарх саналаа шууд гаргах, шийдвэрт тусгуулах боломжийг бүрдүүлжээ. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх www.erdenet.mn цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж, байнгын ажиллагаатай болгоод байна. Тус аймаг нь Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж буй “Шударга нийгмийн төлөө хамтдаа” аянд санаачилгаараа нэгдэж, шударга ёсыг бэхжүүлэх чиглэлээр хүүхэд залуусын дунд төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулжээ.

Хөндлөнгийн хараат бус шинжээчдийн багаас хангалттай үнэлгээ авсан Орхон, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудын ажлыг Авлигатай тэмцэх газар онцгойлон сайшааж, цаашид үйл ажиллагаагаа улам идэвхжүүлэн, бусдадаа үлгэр дуурайл үзүүлж ажиллахыг тэмдэглэж байна.

“Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-ны дүнг танилцуулав

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-ны дүнг өнөөдөр танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолоор “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г жил бүр зохион байгуулж явуулах чиг үүргийг Авлигатай тэмцэх газарт даалгасан бөгөөд судалгааны үр дүн нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийг үнэлэх нэг шалгуур болдог ороо онцлог юм. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн 2014 оны судалгааны дүн 3.58 гэсэн үзүүлэлттэй гарсан нь Монгол Улсад өндөр түвшний авлига түгээмэл байгааг илэрхийлж байна.

Судалгааны явцад зөвхөн өндөр түвшний авлига төдийгүй Монгол Улс дахь авлигын ерөнхий төлөв байдлыг бүхэлд нь болон салбар, хүрээнд шинжээчдээр үнэлүүлээ. 2014 оны авлигын ерөнхий түвшин 3.77 буюу их гэсэн үзүүлэлттэй гарав. Авлигын ерөнхий түвшин өндөр байгаа нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн орчин, улс төрийн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай болохыг судалгааны дүн харуулж байна.

“Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн

судалгаа”-ны асуултуудад дурдсан нөхцөл байдлыг тусгайлан сонгосон шинжээчдээр үнэлүүлдэг бөгөөд өндөр түвшний авлигад хамгийн хүчтэй нөлөөлж буй хүчин зүйл нь албан тушаалын томилгоо, улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийн механизм, улс төрийн хүрэн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил болоод байгааг тэд онцоллоо.

Төв, Ховд аймгийн Засаг даргад авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа эрчимжүүлэх чиглэл өгөв

Авлигатай тэмцэх газар олон нийтийн оролцоонд тулгуурласан, хөндлөнгийн хараат бус “Шинжээчдийн баг”-ийг ажиллуулж, төрийн байгууллагын авлигын эсрэг 2014 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэсэн билээ. Хөндлөнгийн шинжээчдээс Төв, Ховд аймгийн авлигын эсрэг үйл ажиллагаанд хангалтгүй үнэлгээ өгсөн бөгөөд үүний мөрөөр Авлигатай тэмцэх газраас дээрх аймгийн Засаг дарга нарт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа сайжруулах, эрчимжүүлэх чиглэл өгөвд байна.

Төв аймаг дахь төрийн байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулахад чиглэсэн арга хэмжээг хангалтгүй гэж үзсэн бөгөөд удирдлагын санал санаачилга, хүсэл зориг ч мөн дутмаг гэж дүгнэжээ.

Харин Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны тайлан, холбогдох мэдээлэл”-ийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй бөгөөд шинжээчдийн баг үнэлгээг хийхдээ аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас дахь мэдээлэлд тулгуурласан байна. Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг үйл ажиллагааны 2013 оны үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн байгууллагуудад тусгайлан арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр Сүхбаатар, Хөвсгөл, Сэлэнгэ, Баянхонгор, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын үнэлгээ өнгөрсөн оныхоос 16-73 оноогоор нэмэгдэж, зохих үр дүнгээ өгсөн. Гэтэл дээрх аймгуудын нэгэн адил Авлигатай тэмцэх газраас Ховд аймагт чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байтал дахин хангалтгүй үнэлгээ авчээ.

Ийнхүү удаа дараа хангалтгүй үнэлгээ авсаар байгаа Төв, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газарт хандан цаашид үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн дээрх асуудлуудад анхаарлаа хандуулахын зэрэгцээ “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-д тусгасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллах, 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний дүнг зохих түвшинд хүргэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг Авлигатай тэмцэх газраас анхаарууллаа.

ИЛ ЗАХИДАЛ

Нийтлэлч Баабар Танаа

Ташаа тоо баримтыг залруулах тухай

“Өдрийн сонин”-ы 2015 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 052 дугаарт, мөн www.baabar.mn сайтад 2015 оны 2 дугаар сарын 27-ны өдөр нийтлэгдсэн “АТГ-ын хоригдлуудыг Ерөнхийлөгч уучилсан гэнээ, цаана чинь!” гарчигтай Таны нийтлэлийн мөрөөр энэхүү ил захидлыг илгээж байна. Өөрөөр хэлбэл, уг нийтлэлд дурдагдсан зарим үндэслэлгүй тоо баримтыг залруулах шаардлагатай гэж бид үзлээ.

Та нийтлэлдээ “АТГ...өнгөрсөн богино хугацаанд 3500 орчим хувийн хэвшлийн нэгжийг шалган зовоож, 600-д нь эрүү үүсгэжээ...” гэж дурдсан байна. Таны нийтлэлдээ ашигласан энэхүү тоо баримт бодит байдалтай огт нийцэхгүй, ташаа байгааг тэмдэглэн хэлье.

Авлигатай тэмцэх газар нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулах, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, хээл хахууль авах, хээл хахууль өгөх, хээл хахууль зуучлах, хууль бусаар хөрөнгөжих, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, мөнгө угаах гэсэн 10 төрлийн гэмт хэрэгт харьяаллын дагуу мөрдөн байцаалтын ажиллагаа явуулдаг.

Тус газрын эрүүгийн хэргийн судалгаагаар сүүлийн 5 жилд буюу 2010-2014 оны хугацаанд авлига, албан тушаалын 864 (давхардсан тоогоор) гэмт хэргийг шалгажээ. Үүнээс аж ахуйн нэгжийн албан тушаалтнуудад холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 265 дугаар зүйлд заасан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах гэмт хэрэг 64, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 266 дугаар зүйлд заасан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 21 буюу нийт 85 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Авлигатай тэмцэх газрын авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа 2007 оны 9 дүгээр сараас хуулийн дагуу эхэлсэн бөгөөд Таны нийтлэлд бичсэнчлэн “өнгөрсөн богино хугацаа” гэдгийг бид сүүлийн 5 жилийн байдлаар тооцож, албан ёсны, үнэн бодит, үндэслэл бүхий тоо баримтын заримыг энэхүү ил захидлаар харуулж байна. Авлигатай тэмцэх газар олон нийтийн санал бодолд ямагт хүндэтгэлтэй хандаж, тэдний зүгээс ирэх эрүүл шүүмжлэлийг хүлээн авч, ажилдаа тусган хэрэгжүүлдэг билээ. Авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаарх албан ёсны тоо баримтыг Авлигатай тэмцэх газраас авах бүрэн боломжтой бөгөөд энэ нь бодитой, үнэн зөв, хэзээд нээлттэй байх болно.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Хуурамч диплом ашиглан төрийн албанд ажиллаж байгаа зөрчлийг илрүүлэн шалгав

Авлигатай тэмцэх газраас хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд 2015 оны 01 дүгээр сараас эхлэн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 1628 нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянан шалгасан байна.

Мөн хяналт шалгалтаар сүүлийн үед нэр дэвшсэн этгээд нь ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахгүй байх, нэр дэвшигчийн эзэмшсэн боловсрол, мэргэжил, туршлагад нь тааруулсан ажлын

байрны тодорхойлолтыг батлуулж гаргах, зарим нэр дэвшигч нь хуурамч диплом ашиглан төрийн албанд ажиллаж байгаа зэрэг зөрчлүүд тогтоогдлоо. Тус газраас зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах болон хуурамч бичиг баримт ашигласан асуудлыг Цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулах, түүнчлэн нэр дэвшигчидтэй холбоотой асуудлыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран хянан шалгах ажиллав.

Өөртөө урамшуулал олгосон албан тушаалтнуудад хариуцлага тооцууллаа

Авлигатай тэмцэх газраас томилогдсон ажлын хэсэг нийслэлийн Налайх дүүргийн төрийн байгууллагууд дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц байдалтай танилцав.

Шалгалтын явцад холбогдох баримт материалуудыг хянан үзэхэд Налайх дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямсүрэн, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга П.Чинбат, Эрүүл мэндийн төвийн дарга Б.Эрдэнэбат нар нь өөртөө урамшуулал олгосон байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1-т заасныг тус тус зөрчсөн үйлдэл юм. Дээрх албан тушаалтнуудад холбогдох хуульд зааснаар арга хэмжээ авах тухай албан бичгийг харьяа дээд байгууллагууд руу Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн бөгөөд энэ дагуу Налайх дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямсүрэнг албан үүргээс нь чөлөөлж, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга П.Чинбатын үндсэн цалинг 1 сарын хугацаатай 30 хувиар бууруулж, Эрүүл мэндийн төвийн дарга Б.Эрдэнэбатын үндсэн цалинг 3 сарын хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын албан тушаалтнуудын мэдүүлгийг хянан шалгажээ

Авлигатай тэмцэх газраас хуульд заасан чиг үүргийн хүрээнд 2015 оны 1 дүгээр сард төлөвлөгөөт хяналт шалгалтаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын албан тушаалтнуудын болон иргэдийн гомдол мэдээллийн дагуу нийт 126 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгав. Түүнчлэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын холбогдох албан тушаалтнуудын хөрөнгө,

орлогын мэдүүлгийг хянан шалгаж байна. Хяналт шалгалтаар хөрөнгө, орлогын мэдүүлгээ зөрчилтэй мэдүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нь албан бичиг хүргүүлснээр зөрчил гаргасан 2 албан тушаалтанд сануулах, 8 албан тушаалтанд цалинг 3 хүртэл сарын хугацаанд 30 хувь бууруулах сахилгын арга хэмжээг авсан байна.

Иргэдээс үндэслэлгүй авч байгаа 20 000 төгрөгийн хураамжийг таслан зогсоох шаардлагатай

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, чиг үүргийг судлан танилцах зорилгоор Барилгын хөгжлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт ажиллав.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг тус байгууллагын мэдээллийн ил тод нээлттэй байдал, эрх бүхий албан тушаалтныг мэдээлэл арга зүйгээр хангах, холбогдох дүрэм журмуудыг судлан үзэж, удирдлагын түвшинд байгууллагыг хэрхэн авлигаас ангид байлгах талаар болон ажилтан, албан хаагчдад хууль сурталчилж ажиллав. Мөн хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, барилга байгуу-

ламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ хийх эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журмын хүрээнд явуулж байгаа үйлчилгээнд иргэдээс үндэслэлгүй хурааж байгаа 20 000 төгрөгийн хураамжийг таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэх иргэн, аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалттай холбогдох журмыг ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, гэрчилгээний олголт, сунгалт, нэмэлт ажил бүхий мэдээллүүд хугацааны хамт нээлттэй болгох зэрэгт анхаарч ажиллахыг даалгав.

ДЭЛХИЙ ДАХИНД

ОХУ-ын 3 албан тушаалтан тутмын 1 нь хахууль авч байна

ОХУ. Тус улсын Авлигын эсрэг хорооны дарга Кирилл Кабанов “Манай улсын 3 албан тушаалтан тутмын 1 нь хахууль авсаар байгаа нь орон нутагт тархсан авлигатай тэмцэхэд маш их бэрхшээлтэй байна. Төрийн албан тушаалтнуудын бараг 30 хувь нь авлигад автсан” гэж хэлжээ. Түүнийг ийнхүү мэдэгдэхээс ердөө нэг хоногийн өмнө Ерөнхийлөгчийн захиргааны албаны дарга Сергей Иванов “Хээл хахуулийн эсрэг тэмцэлд амжилт гарч байгаа. Өөрсдөд нь хахууль санал болгож буй хүмүүсийн талаар ОХУ-ын төрийн албан тушаалтнууд мэдэгддэг болсон. Бид энэ жил ийм төрлийн 3000 гаруй гомдол хүлээн авсан нь төрийн албан тушаалтнуудын дунд хариуцлага нэмэгдэж байгааг харуулж байна” гэсэн билээ.

Авлигын эсрэг хорооны дарга Кирилл Кабановын хэлснээр нэн түрүүнд бизнесийн хүрээний авлигыг устгахгүй бол хээл хахуульд автсан төрийн албан тушаалтнуудтай тэмцэх нь ямар ч боломжгүй зүйл ажээ. ОХУ нь 1990-2000 оны үе дэх бага цалинтай, хяналтын тогтолцоо муу, албан тушаалтнууд нь хахууль авч орлогождог байсан уламжлалаасаа ангижрахын тулд тэмцсээр байгаа ч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

Ираны Ерөнхийлөгч Хассан Роухани авлигын эсрэг сэрэмжлүүлэв

Иран. Тус улсын Ерөнхийлөгч Хассан Роухани Тегеранд болсон авлигын эсрэг үйл ажиллагааны үеэр телевизэд өгсөн ярилцлагадаа “Ширээн доогуур өгч, авалцдаг мөнгөө одоо ил дээгүүр нь өгдөг болжээ. Үүнийг устгахыг уриалж байна” гэжээ.

Түүний Засгийн газар 2013 оны 8 дугаар сараас хойш төр барьж эхэлснээс хойш хэд хэдэн өндөр албан тушаалтны авлигын хэргүүд ил гарсан юм. Өнгөрсөн 5 дугаар сард тэрбумтан Махафарид Амир Хосравиг 14 төрийн өмчит болон хувийн өмчийн банкуудаас нийтдээ 2.6 тэрбум ам.долларын өмч хөрөнгө шамшигдуулсан, хээл хахууль авсан, хуурамч бичиг баримт бүрдүүлж мөнгө угаасан зэрэг томоохон хэргийн ард байсан нь илэрснээр түүнийг ялласан байна. Мөн 9 дүгээр сард Дэд Ерөнхийлөгч

асан Мохаммад Реза Рахимиг авлигын хэрэгт холбогдуулан хорьсон юм. Түүнийг Ираны тэрбумтан Баба Занжанитэй холбоотой гэж мэдэгдсэн бөгөөд түүнийг өөрийн компаниудаар дамжуулан Засгийн газрын нэрийн өмнөөс борлуулсан Ираны нефтийн орлого болох 2.8 тэрбум ам.долларыг шамшигдуулсан хэрэгт буруутгажээ.

Ерөнхийлөгч Хассан Роухани иранчуудыг авлигатай тэмцэхэд бүхий л хүчээ ашиглахыг уриалсан бөгөөд “Хээл хахууль, авлига өргөжиж байгаа нь Исламын хувьсгалд аюул учруулж байна, буу зэвсгийн үйлдвэрлэл, түүний сурталчилгаа хүртэл бүгд авлигын шалтгаан болж байна” хэмээн хэлсэн байна. Мөн тэрээр монополийг маш их шүүмжилсэн бөгөөд “Ямар ч өрсөлдөөнгүй монополичлогдсон бүхэн авлигыг өөгшүүлж байна, үүнийг уг үндсээр нь арилгах хэрэгтэй” гэсэн байна.

Авлигын хэргээр хотын дарга “Бульдозер Жи” 15 жилийн хорих ял авлаа

БНХАУ. Ши Зиньпиний тэргүүлж буй авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд авлигын хэрэгт холбогдсон



хамгийн сүүлийн өндөр түвшний албан тушаалтнаар Нанжин хотын дарга асан Жи Жианьэ тодроод байна. Түүнийг авлигын хэрэгт буруутай болохыг тогтоож, шүүхээс 15 жилийн хорих ял оногдуулав.

Янтай хот дахь Ардын давж заалдах шатны шүүх Жи Жианийг 1999-2012 оны хооронд хээл хахуульд 2.37 сая ам.доллар авсан хэрэгт буруутай болохыг тогтоосон талаар өөрийн цахим хуудсаар мэдэгдэв. Шүүхийн мэдэгдэлд “Өөрийнхөө бурууг хүлээж, чин санаанаас гэмшсэн Жи Жианьэд шүүхээс зарим ялыг нь хөнгөрүүлсэн” гэжээ. “Бульдозер Жи” гэх хочтой Жи Жианьээс хууль сахиулах байгууллагууд 420 000 ам. долларын

өртөг бүхий эд хөрөнгө хураан авсан байна. “Бульдозер Жи” нь 2010 нь Нанжин хотын дарга болохоосоо өмнө Куньшань болон Яньжоу хотыг удирдаж байсан юм. Өөрөөр хэлбэл, Жи Жианьийн улс төрийн бүхий л замнал Жянсу мужтай холбоотой юм. Жи болон түүний гэр бүлийн гишүүд үлэмж хэмжээний мөнгө болон бэлэг хүлээн авсан, хууль зөрчсөн талаар тус улсын хууль сахиулах байгууллагууд мэдэгдсэний дараа буюу 2014 оны 1 дүгээр сард түүнийг Коммунист намаас хөөсөн билээ. Жи-гийн улс төр дэх уналтыг өөрийн ойр дотны этгээдийн компанид барилгын төслүүдийг шилжүүлсэн явдалтай холбоотой хэмээн төрийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж байсан юм.

Нанжин бол Жянсу мужийн нийслэл хот бөгөөд хөрш Шаньдун мужид орших Янтай хот дахь Ардын давж заалдах шатны шүүхээр хэлэлцэн түүнийг шийтгэсэн юм. Хятадад гэмт хэрэгт буруутгагдаж байгаа албан тушаалтнуудыг амьдарч байгаа нутгийнх нь эрх мэдэл бүхий этгээдүүдээс ангид байлгахын тулд хэргийг өөр мужийн шүүхээр шийдвэрлэдэг байна.

Канадын Ерөнхий сайдын туслах асны үйлдсэн хээл хахууль, залилангийн хэргийг шүүж байна

Канад. Ерөнхий сайд Стивен Харперын туслах асан Майк Даффигийн хээл хахууль, залилангийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. Телевизийн нэвтрүүлэгч байсан Майк Даффийг Эрүүгийн хуулийн 31 зүйлээр буруутгаж байна.

2013 онд Ерөнхий сайд Стивен Харперийн ажлын албаны дарга асан Нигель Райтад 72000 ам.долларын чек өгсөн талаараа өөрийн амьжиргааны зардлын тайландаа тусгаагүй нь нэлээд сонирхол татах хэргүүдийн нэг юм. Өнгөрсөн онд энэ хэргийн талаар олон нийт мэдсэний дараа Нигель Райт ажлаасаа халагдаж, харин Ерөнхий сайд Стивен Харпер энэ тухай юу ч мэдэхгүй гэдгээ илэрхийлсэн билээ. Засгийн газраа илүү хариуцлагатай болгохоо амлан 2006 оны эхээр эрх мэдлийг авч байсан Консерватуудад энэ шүүх хурал ноцтой бэрхшээл учруулж магадгүй болоод байгаа юм. Хэргийн шүүх хурлыг 4, 5, 6 дугаар сард явуулах бөгөөд нийтдээ 41 өдөр хуралдахаар товлосон байна.

АВЛИГЫН ХАВТАСТ ХЭРЭГ

Хятад иргэнээс хахууль авсан ахлах байцаагчид хорих ял

ОНООВ

Авлигатай тэмцэх газраас мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгасан Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Ж.Пунцаг нарт холбогдох хэргийг 2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн хуралдаанаар шийдвэрлэв.

Ж.Пунцаг нь 2014 оны 10 дугаар сарын 2-ны өдөр “Си Ар Си Жи девелопмент Монголиа” ХХК-ийн орлогч захирал Жан Юү Шингээс 5 сая төгрөгийг орчуулагч Жя Рун Лингээр дамжуулан авсан бөгөөд 2014 оны 7, 8 дугаар сард бизнес ангиллын визээр Монгол Улсад зорчин ирсэн боловч ажил эрхэлж байгаад визийн хугацаа хэтрүүлсэн 14 хятад иргэнийг дахин хил нэвтрэх эрхтэйгээр нутаг буцаасан болох нь мөрдөн байцаалтаар нотлогдсон юм. Ж.Пунцагт хээл хахууль өгсөн Жан Юү Шин нь Монгол Улсад 2014 оны 6 дугаар сард ирсэн бөгөөд БНХАУ-ын төмөр замын бүтээн байгуулалтын улсын компаниас хөрөнгө оруулалттай “Си Ар Си Жи девелопмент Монголиа” ХХК-ийн орлогч захирлаар ажиллаж байгаа ч түүнийг орлогч захирлаар томилсон албан ёсны тушаал шийдвэр байдаггүй ажээ.

Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн хуралдаанаас Ж.Пунцагт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар 1 жил 6 сар хорих ял ногдуулж, БНХАУ-ын иргэн Жан Юү Шин-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэн хэмжээ /9.5 сая төгрөг/-гээр, Монгол Улсад түр оршин суух Жя Рун Лин-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлийн 270.1-д зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэн хэмжээ /950.000 төгрөг/-гээр тус тус торгох, хэргийг шийдвэрлэсэн байна.

Гаалийн улсын ахлах байцаагчид 2 жилийн хорих ял оноов

Авлигатай тэмцэх газраас мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгасан Буянт-Ухаа дахь гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч П.Нямдорж нарт холбогдох хэргийг 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдөр Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хуралдаанаар шийдвэрлэв.

Иргэн Д.Энхтулга нь Хонгконг-Улаанбаатарын чиглэлийн агаарын хөлгөөр зорчиж Буянт-Ухаа боомтоор их хэмжээний гар утас оруулж ирэх үед нь гаалийн улсын ахлах байцаагч П.Нямдорж нь гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг төлүүлэхгүйгээр урьдчилан амлаж, иргэн Д.Энхтулга, Ю.Эрдэнэчимэг, Б.Очирхүү нараас 800 мянган төгрөгийг хээл хахуульд авч, татварт төлөх 20.507.658.94 төгрөгийг төлүүлэлгүйгээр улсад үлэмж хэмжээний хохирол учруулсан нь мөрдөн байцаалтаар тогтоогджээ.

АВЛИГЫГ МЭДЭЭЛЭХ УТАС

18001969

Энгийн утасны тарифаар

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хуралдаанаас Буянт-Ухаа дахь гаалийн газрын улсын ахлах байцаагч П.Нямдоржийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар төрийн албанд ажиллахаар эрхийг 2 жилийн хугацаагаар хасч, 2 жил хорих, иргэн Д.Энхтулгыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2, 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар 3 жил 6 сар хорих ял тус тус оноов. Иргэн Б.Очирхүүг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлийн 270.1-д зааснаар гэм буруутайд тооцож, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, иргэн Ю.Эрдэнэчимэгийг цагаатгаж, П.Нямдоржийн хээл хахуульд авсан 800 мянган төгрөгийг улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна.

20 сая төгрөгийн хахууль авсан Онцгой байдлын ахлах мэргэжилтэн 5 жилийн хорих ялаар шийтгүүлэв

Авлигатай тэмцэх газраас мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгасан Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн буюу тасгийн дарга албан тушаалтай Д.Тогооням нарт холбогдох хэргийг 2015 оны 3 дугаар сарын 6-ны өдөр дүүргийн эрүүгийн I шүүхийн хуралдаанаар шийдвэрлэв.

Д.Тогооням нь Өмнөговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн галын депогийн барилгыг барьсан “Говь Гурван Сайхан” ХХК-ийн захирал н.Цэдэнсамбаас 20 сая төгрөгийн хээл хахууль авчээ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасан “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах” гэсэн заалтыг хэрэгжүүлэхгүй байх, санхүүжилтийг бүрэн олгох, мөн 2011 онд нийслэлийн Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Гал унтраах 65 дугаар ангийн барилгын гүйцэтгэгчээр “Говь Гурван Сайхан” ХХК-ийг шалгаруулахаар урьдчилан амласан бөгөөд 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Өгөөж” ХХК-ийн урд автомашины зогсоол дээр 20 сая төгрөг авсан үйлдэл нь мөрдөн байцаалтаар тогтоогджээ.

Дүүргийн эрүүгийн I шүүхээс Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн буюу тасгийн дарга Д.Тогоонямд 5.1 жил, н.Цэдэнсамбад 1.1 жилийн хорих ял оногдуулсан байна.

Албан тушаалын байдлаар урвуулан ашигласан Ойн ангийн дарга Д.Тэрбишийг 9 сая 984 мянган төгрөгөөр торгох ял оноов

Авлигатай тэмцэх газраас мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгасан Сэлэнгэ аймгийн Ерөө сумын сум дундын ойн ангийн дарга Д.Тэрбиш нарт холбогдох хэргийг 2015 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Сум дундын 20 дугаар шүүхийн хуралдаанаар шийдвэрлэжээ.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын сум дундын Ойн ангийн дарга Д.Тэрбиш нь 2013 оны 12 дугаар сард албан тушаалын байдлаар урвуулан ашиглаж Хүдэр суманд үйл ажиллагаа явуулдаг хэрэглээний мод бэлтгэх эрхгүй “Хүдэр өсөх” ХХК-ийн захирал Р.Лхагвадоржтой тохиролцон Ерөө сумын нутаг дэвсгэр “Баяны ар” гэх газарт хууль бусаар нойтон мод бэлтгүүлж байгаль экологид онц их хэмжээний буюу 59.3 сая төгрөгийн хохирол учруулсан байна. Ойн ангийн мэргэжилтэн Н.Буяндэлгэр нь мод бэлтгэж эхлэхээс өмнө газар тусгаарлалт хийх ёстой байсан боловч мод бэлтгэж эхэлснээс хойш 5.5 га газарт тусгаарлалт хийж албан үүрэгтээ хайнга ханджээ.

Сум дундын 20 дугаар шүүхээс Ойн ангийн дарга Д.Тэрбишид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 2 жилийн хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 52 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээ буюу 9 сая 984 мянган төгрөгөөр торгох ял оногдуулав. Түүнчлэн Ойн ангийн мэргэжилтэн Н.Буяндэлгэрт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар нэг жилийн хугацаагаар хорих ял, “Хүдэр өсөх” ХХК-ийн захирал Р.Лхагвадоржид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 211 дүгээр зүйлийн 211.2-т зааснаар 2 жилийн хорих ял тус тус оногдуулжээ. Ар гэрийн байдлыг нь харгалзан үзэж, Н.Буяндэлгэр, Р.Лхагвадорж нарт хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг тодорхой хугацаагаар хойшуулж шийдвэрлэсэн байна.

ХЭН ЮУ ХЭЛЭВ?

Д.Содном: Авлига гэдэг дайсантай ард иргэд бүгдээрээ хүч хавсарч дайтахгүй бол дарагдахгүй

Монгол Улсын Ерөнхий сайд асан
Думаагийн Содном:

...Онц их аюул бол авлига. Авлигыг сэжиглэсэн хүн бүхэн зохих газарт нь нууцаар боловч заавал мэдээлдэг болмоор. Авлигын эсрэг тэмцэж байгаа байгууллага, тэнд ажиллаж байгаа нөхдийг хамгаалж дэмжиж байцаая, цагдаа нараа хайрлаж байа гэж уриалмаар байна. Авлигын асуудалд холбогдсон л бол ямар ч эрхтэн, дархтан байх нь хамаагүй шалгалт байцаалтад ямар ч саадгүй очиж учраа олдог, хэрэв буруутай нь илэрсэн бол оногдуулах ялыг улам чангатгасан байхад буруудахгүй. Авлига гэдэг дайсантай ард иргэд бүгдээрээ хүч хавсарч дайтахгүй бол дарагдахгүй.

Эх сурвалж: "Өдрийн сонин". 2015.04.08.
№087, 088 (5039, 5040)



Ардчилал бол амиа бодож, нийтийн хөрөнгөөр хагартлаа баяж гэсэн үг биш

Судлаач Минжигдоржийн Найданхүү:

Авлигатай тэмцэх газар (АТГ) байгуулагдан 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Байгуулагдсанаас эхлээд ацулуудыг барьсангүй, жараахай нартай л тэмцлээ гээд хэвлэлийн болон олон нийтийн шүүмжлэл дагуулсан.

АТГ-ын үйл ажиллагаа идэвхижиж том том хөрөнгө мөнгө нэн ялангуяа түмний баялаг болсон орд газрын наймаа, лиценц эзэмшил, буруу хөрөнгө оруулалтаар хаацалсан мөнгө угаалт, улсын эд хөрөнгийн шамшигдуулалт, хууль бус хувьчлал, хууль бус өмчлөлт, хууль бус баяжилт... зэрэг улс орны тусгаар тогтнолд хамааралтай гэмт хэргүүд, гэмт хэрэгтнүүдийг илрүүлж эхэлсэн. Н.Энхбаяр гуайгаас эхлээд шалгаж эхэлсэн. АТГ-ын үйл ажиллагаа идэвхижээд эхлэхээр ард олон буруутнуудаа хаацаллаад, өмөөрөөд эхлэх нь Монгол араншин гэлтэй. Олон түмэнд очих ёстой байсан цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгө, сургууль, цэцэрлэг, эмнэлэг барих хөрөнгийг хулгайлчихсан л этгээдүүд шүү дээ!

Улс эх орны тусгаар тогтнол, баялгийг үнэгүйдүүлэх боломжит аюул нь энэ цаасан зөвшөөрлүүд болох Монголын баялгийг эзэмших гэрчилгээ, лиценц... зэргүүд юм. Өнөөдөр манай баялаг хувь шуналдаа автсан хэдхэн этгээдийн гар, хөлийн үсгээр дамжаад авлигад өртөөд бусдын эзэмшилд шилжээд байна. Хүн бүр гасалж байна. Хэдэн халтар цаасанд нь авлигадуулсан нянгаруудыг үзэн










ядацгааж байна. Алга дарам цаасаар асар уудам нутаг, ус, баялагтай орд газруудаа төрийн нэрээр хуйвалдаж, албан тушаалаараа дулдуйдаж хулгайлж, хахуульдаж лиценц нэрээр авчихаад хөрөнгө оруулалт нэрээр гадныханд зарж байна. Тэр хэрээр Эх орны минь тусгаар тогтнол алдагдаж буйг үл ойлгоно.

Төрийн нэр барьж түмний баялгийг үрж, үнэгүйдүүлж, үрэн таран хийж буй гол буруутнууд хэн бэ? Буруу, зөвийг нь шалгаж тогтоохын тулд АТГ ажиллаж байна. Зүгээр яваа мань мэтийг хоморголж барьж аваачаад хорьчихоогүй байна. Юманд жаахан учиртай хандъя! Ардчилал, хүний эрх нэрээр бүх л хийсэн булхайгаа нуух гэсэн этгээдүүд олшроод л байна. Ардчилал гэдэг нийтийн эрх ашгийг дээдэл гэсэн үг болохоос хувийн эрх ашгаа нэн тэргүүнд тавьж амиа бодож, нийтийн хөрөнгөөр хагартлаа баяж гэсэн үг биш юм.



Авлигатай тэмцэх газрын талаар нийгмийн мэдээллийн сүлжээнд...

-  @KhadkhuuV
АТГ зарим хүний дургүйг хүргээд байгаа бололтой. Авлигачин биш, шударгаар хөдөлмөрлөж байвал энэ газартай орооцолдохгүй байж болох биш үү.
-  @NenSoniuch
АТГ-ыг юунд нүд үзүүрлэв? Төрлөөрөө сүрэглэн төсвөөс зулгаах "Акул"-уудыг агналаа гэж тэр үү? "Жараахай" гохдоод ажилгүйгээр дуудуулаад сууж байх юм уу?
-  @enkhbat_
Номин Баярсайхан АТГ нь шалгасан аймшигт жилүүд эхэллээ гэсэн. Урьд нь та нар огт шалгуулдаггүй луйварддаг аймшиггүй он жилүүдэд амьдарч байсан.
-  @batupu
АТГ ард түмнийг айдастай амьдруулж байна ч гэх шиг. Авлига авч, хулгай хийсэн хүмүүс л айдастай байдаг байх даа.
-  @AmartuvshinD
УИХ-ын гишүүн Д.Дондогт 10 жилийн ял өгсөн гэж байна. АТГ-ыг ажлыг нь хийлгэ л дээ. Авлига Монголыг муухай харагдуулж байгаа нь үнэн шүү дээ.
-  @TumurTungalag
АТГ хэлмэгдүүлдэг гэх үгсийг зөвхөн айх юмтай албан тушаалтнууд амнаасаа унагадаг бололтой.
-  @BazarsadL
Авлигачид, айдас тээсэн хамсаатан нар нь л АТГ-ыг араандаа зуучихаад боргоогоод байна гэж боддог. Буруу юу зөв үү?